



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/105

Арвайхээр сум

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 зүйлийн 60.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан “Аймгийн 2023 оны төсөв батлах тухай” 15/06 дугаар тогтоолын 3.2.1.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, түүний Тамгын газрын бодлого, шийдвэр, үйл ажиллагааг иргэд, олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх ажлыг төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар гэрээгээр гүйцэтгүүлэх зардлыг хавсралтаар баталсугай.

2. Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан, гүйцэтгэлийн дагуу батлагдсан зардлаас санхүүжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0186

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар  
сарын 27-ны өдрийн 7/МС дүгээр  
захирамжийн хавсралт

ТӨВИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН  
БАЙГУУЛЛАГУУДААР 2023 ОНД ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН  
ЗАРДЛЫН ХУВААРЬ

Д/д	Хэвлэл мэдээллийн байгууллагуудын нэр	Санхүүжилт (Мян.төг)
1.	МҮОНТ-ийн Орон нутаг дахь сэтгүүлч	6000,0
2.	“Соёмбо” телевиз	6000,0
3.	“Хас” телевиз	6000,0
4.	“Арвайхээр чөлөөт суваг” телевиз	6000,0
5.	Uvlive.mn сайт	6000,0
6.	“Өвөрхангайн өнгө” сэтгүүл	5000,0
7.	“Өвөрхангайн мэдээ” сонин	5000,0
8.	“Ноён-Уул” богино долгионы радио	4000,0
9.	Монголын радиогийн сурвалжлагч	2000,0
10.	“Оюу нана брэнд” ХХК	5000,0
11.	Төвийн хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах	9000,0
НИЙТ		60000,0

-оОо-